

**“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН  
2023-2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ**

**ОРШИЛ**

Эвслийн 2023-2025 онд баримтлах стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын боловсролын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад эвслийн зүгээс бодитой хувь нэмэр оруулан ажиллах, Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго болох бүх нийтэд чанартай, тэгш хамруулсан боловсролыг эрх тэгш олгох зорилгыг үйл хэрэг болгохын тулд эвсэл болон түүний гишүүн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар төлөөлж байгаа бүлгүүдийн сурч боловсрох эрхийг түүштай, үр дүнтэй хангахад чиглэнэ.

Эрүүл, аюулгүй сургуулийн орчинд үр дүнтэй багшлахуй, суралцахуй, дэвшилтэт технологиор дамжуулан хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд дасан зохицож, ижилсэж амьдрах чадвартай иргэнийг бий болгох уян хатан, санхүүжилтээр баталгаажсан чанартай боловсролын үйлчилгээг хүн бүрт хүргэх шаардлагатай байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг эвслийн гишүүн байгууллагууд, салбар зөвлөлүүд, дэмжигч гишүүд гардан хэрэгжүүлэх ба иргэд олон нийт, төр, иргэний нийгмийн бусад байгууллагууд, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж хэрэгжүүлнэ.

**НЭГ. АЛСЫН ХАРАА**

Хүн бүрд хүртээмжтэй; хүний эрх, жендэрийн тэгш эрхэд суурилсан; цогц чадамжийг өөртөө тохиромжтойгоор, ялгаварлан гадуурхалтгүйгээр, насан туршдаа эзэмших боломжтой; эрүүл, аюулгүй орчин бүрдсэн; ялгаатай хэрэгцээг хангасан; хүмүүнлэг, ардчилсан; бүх нийтийн; хангалттай санхүүжилттэй; сайн засаглал бүхий чанартай, хувиран өөрчлөгдөх боловсролын тогтолцоо.

**ХОЁР. УРИА**

Боловсролыг бүх нийтэд-Бүх нийт боловсролын төлөө!

**ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Иргэний нийгмийн олонлог төлөөллийг чадавхжуулан эрх мэдэлжүүлж, эв нэгдлээ бэхжүүлж, боловсролын тогтолцоог хувирган өөрчлөхөд нөлөөлнө.

## ДӨРӨВ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Хамтын зорилгын төлөө нэгдмэл байр суурь илэрхийлж, ёс зүй, хариуцлагыг эрхэмлэн ажиллана;
- Хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэгш хамруулах соёлыг төлөвшүүлж бусдад үлгэрлэнэ;
- Ил тод, нээлттэй, ардчилсан зарчмаар ажиллана;
- Олон талын оролцоо, олон ургалч үзэлд тулгуурлана;
- Нээлттэй, тэгш хамтын ажиллагаа, өргөн түншлэлийг хөгжүүлнэ;
- Гишүүн байгууллагуудын идэвхтэй, утга учиртай оролцоонд тулгуурлана
- Хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлнэ;
- Хариуцлага, үр дүнг шаардах иргэдийн чадавхыг хөгжүүлнэ;
- Төрийн байгууллагуудтай бүтээлчээр хамтран ажиллах арга-хандлагыг баримтална;
- Шударга ёс, хуулийг удирдлага болгоно;

## ТАВ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Боловсролыг насан туршдаа суралцахуйн өнцгөөс хүний эрхэд суурилсан байдлаар харна.

### Стратегийн зорилтууд

1. Боловсролын дотоодын/ төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, эрх тэгш байдлыг хангах
2. Боловсролын чанарыг сайжруулах
3. Сургуулийн/боловсролын засаглалыг сайжруулах
4. Боловсролын орчин, дотуур байран дахь хүүхэд хамгааллыг сайжруулах
5. Хөдөлгөөнөө бэхжүүлэх

Энэ стратегийн зорилгыг хангахын тулд дараах **хөтөлбөрүүдийг** хэрэгжүүлнэ:

- Боловсролын салбарын санхүүжилтийн хөтөлбөр
- Боловсролын чанар болон тэгш хамруулах хөтөлбөр
- Боловсролын засаглалын хөтөлбөр,
- Боловсролын орчин, дотуур байран дахь хүүхэд хамгааллын хөтөлбөр
- Эвслийн хөгжлийн хөтөлбөр

Дээрх хөтөлбөрийн хүрээнд гишүүн байгууллага, орон нутгийн салбар зөвлөлүүд нь дараах чиглэлээр **үйл ажиллагаа** явуулна:

- Сурч боловсрох эрхийн хүрээнд судалгаа, мониторинг, дүн шинжилгээ хийх,
- Нотолгоонд үндэслэн эвслийн бодлогын байр суурь, санал, зөвлөмж боловсруулах

- Боловсролын бодлогын нөлөөллийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх

Хөтөлбөрүүдийн хүрээнд гишүүн байгууллагууд нь сэдэвчилсэн багаар ажиллаж, харилцан суралцах, хийнгээ чадавхжих, үйл ажиллагаагаа үялдуулах замаар хүчээ нэгтгэж хамтран ажиллана.

#### ЗУРГАА. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

Эвслийн стратегийн зорилтуудыг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Энэхүү стратегид тусгагдсан зорилтуудыг эвслийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

Эвслийн стратегид тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийг зохион байгуулах ерөнхий удирдлагыг Ерөнхий зохицуулагч хариуцаж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх дүгнэх ажлыг 1,5 жил тутамд зохион байгуулж, гишүүдэд тайлагнана.

#### ДОЛОО. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

“Боловсролын төлөөх дүү хоолой” сангаас санхүүжилт авах нөхцөл, болзлоос шалтгаалан энэхүү баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба эвслийн Удирдах зөвлөлийн гишүүд, гишүүн байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

#### НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН

Зорилтууд	Нотолгоо/ нөхцөл байдлын мэдээлэл, кейс зэрэг анхдагч мэдээлэл цуглуулах, судалгаа хийх	Дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт/ Байр сууриа тодорхойлох	Бодлогын нөлөөлөл, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	Хүрэх үр дүн	Суурь үзүүлэлтүүд	Шалгуур үзүүлэлтүүд
<p><b>Боловсролын дотоодын/ төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, нийслэл, дүүрэг, сургуулийн түвшний төсвийн зарцуулалтыг болон төсөв боловсруулах, хэлэлцэх, батлагдах үйл явцыг мөшгөх</li> <li>• Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтийн шинэчлэлээр шинээр нэмэгдсэн болон хэмжээ нь нэмэгдсэн зардлын зүйл ангийн сургууль, цэцэрлэгийн түвшний зарцлалт/хэрэгжилтэд мониторинг хийх</li> <li>• Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн бодлогын хэрэгжилтэд мониторинг хийх</li> <li>• Боловсролын санхүүжилтийг жил бүр хянах</li> <li>• Боловсролын салбарт хэрэгжиж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгах саналд дараах асуудлуудыг багтаах:             <ol style="list-style-type: none"> <li>1) Улсын төсвийн зарлагын 20%-иас доошгүйг Боловсролын салбарт хуваарилах</li> <li>2) Боловсролын санхүүжилтийн боловсролын сургалтын байгууллага болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог, жендэрийн мэдрэг байдлыг нэмэгдүүлэх</li> <li>3) Төсвийн үйл явц дахь иргэд, ТНБ-уудын оролцоо, хяналтын эрхзүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх</li> </ol> </li> <li>• Боловсролын төсвийн боловсролын сургалтын байгууллага, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог, жендэрийн мэдрэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбарын төсөв, санхүүжилт, хувьсах зардлын шинэчлэлийн судалгаанд үндэслэн 4S зарчим үйлчлэх шаардлагатай талаар бодлогын түвшинд шаардах, нөлөөллийн ажил хийх</li> <li>• Улсын Их Хуралд лобби бүлэг байгуулж, ажиллах</li> <li>• Хувийн сургуулийн төсвийн санхүүжилтэд төрийн хяналт, зохицуулалтыг бий болгох</li> <li>• Хөгжлийн албан ёсны тусламж, татварын шударга ёс, боловсролын салбар дахь авлигын асуудлаар бусад ТББ-уудтай хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын төсвийн 4s зарчмын талаар гишүүн байгууллагууд, бодлого гаргагчдын ойлголт нэмэгдсэн байна.</li> <li>• Гишүүн байгууллагууд сургуулийн болон орон нутгийн түвшинд төсвийг мөшгөх чадвараа дээшлүүлсэн байна</li> <li>• Боловсролын төсөв нэмэгдэх зорилт намуудын мөрийн хөтөлбөр болон ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна.</li> <li>• Төсвийн норм, нормативт өөрчлөлт орсон байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 2022 онд ЕБС-ийн төсөвт багшийн хөгжил, дижитал холболтын зардал шинээр нэмэгдсэн.</li> <li>• ЕБС-ийн нийт хувьсах зардалд сургалтын үйл ажиллагаатай холбоотой зардал 2022 онд 3,6% байна.</li> <li>• 2022 онд боловсролын төсвийн улсын төсвийн зарлагад эзлэх хувь 13% байна.</li> <li>• 2022 онд боловсролын төсвийн ДНБ-д эзлэх хувь 4,9% байна.</li> <li>• Хувийн сургуульд өгч буй санхүүжилт бүхэл дүнгээр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн төсөвт сургалтын үйл ажиллагаанд зарцуулах төсвийн эзлэх хувь</li> <li>• Ерөнхий боловсролын нэг суралцагчид оногдох төсвийн зардлын хэмжээ</li> <li>• Нормативт зардлуудын өөрчлөлт</li> <li>• Боловсролд зарцуулж буй улсын төсвийн хэмжээ</li> <li>• Тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн санхүүжилтийн төрөл, хэмжээ</li> <li>• Хувийн сургуульд зориулсан төсвийн санхүүжилтийн дэмжлэгийн ил тод байдал ба тавигддаг нөхцөл болзол</li> </ul>

	байгаа төслүүдэд хөндлөнгийн үнэлгээ, мониторинг хийх <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын төсвийн ил тод байдал, 4 S зарчмын хэрэгжилтээр тайлан гаргах</li> </ul>	байдлыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох <ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн санхүүжилтийн асуудлаар зөвлөмж гаргаж, УИХ-ын байнгын хороо, СЯ-нд хандах</li> <li>• Цуврал хэлэлцүүлгүүд хийх: УИХ-ын байнгын хороо, судлаачидтай гэх мэт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжилтийн тэгш бус байдлын асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн үйл явц дахь иргэд, ИНБ-ын оролцоо, хяналт хууль эрх зүйн хувьд баталгаажсан байна.</li> </ul>	тайлагнагддаг, ямар нэг нөхцөл болзолгүй олгогддог <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын төсөв төсвийн орлого, эдийн засгийн өсөлтөөс хамааралгүй өөрчлөгдөж байна.</li> </ul>	
<b>Боловсролын чанарыг сайжруулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хөтөлбөр, 21 зууын үр чадвар/цогц чадамжийн талаарх эвслийн гишүүдийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх</li> <li>• Маргиналчлагдсан бүлгийн суралцагчдын боловсролын эрэлт хэрэгцээ, суралцахуйд тулгарч байгаа саадыг тодорхойлох судалгаа хийх (оюуны бэрхшээлтэй, сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүд гэх мэт)</li> <li>• Бүх түвшний боловсролд сурагчдыг тэгш хамруулж байгаа сайн туршлагыг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хөтөлбөрийг чадвар, чадамжид суурилан боловсруулах, багш бэлтгэхээс эхлээд багшлахуй, үнэлгээнд нэвт шингээх талаар санал, зөвлөмж боловсруулах</li> <li>• Боловсролын чанар, сургалтын хөтөлбөр ба багшлахуйг “Боловсрол: чанар, санхүүжилт, хариуцлага” чуулганаар хэлэлцэж, иргэний нийгмийн санал, зөвлөмж гаргах</li> <li>• Маргиналчлагдсан бүлгийн боловсролын талаарх судалгаа, мониторингийн дүнг сургууль, багш, эцэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• СӨБ, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үйл явцад оролцож, дараах асуудлыг тусгах чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах: <ul style="list-style-type: none"> <li>○ Суралцагчийн чадвар, чадамжид суурилах - судлагдахуун төвтэй биш хөтөлбөр</li> <li>○ Багшлахуй суралцахуй нь мэдлэг хамтаар бүтээх интеграцчилсан арга зүйгээр зохион байгуулагдах</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хөтөлбөр чадвар, чадамжид суурилан боловсруулагдсан байна.</li> <li>• Маргиналчлагдсан бүлгийн хүүхдийн ердийн сургуульд тэгш хамрагдалтад тулгарч байгаа асуудлуудыг мэдэж, ойлгодог төрийн албан хаагчдын тоо нэмэгдсэн байна.</li> <li>• Боловсролд тэгш хамруулах, эрх тэгш байдлыг хангах зорилтууд улс төрийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын агуулга, хөтөлбөр судлагдахуун болон мэдлэгт суурилсан.</li> <li>• 23,122 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын гадна байна.</li> <li>• Хос хэлний бодлого нарийн зохицуулалт үгүй тул үндэстний цөөнхийн СӨБ, бага боловсролд хамрагдалт доогуур, сургууль завсардалт өндөр, сурлагын чанарын үнэлгээ доогуур байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцад чиглэсэн хэлэлцүүлэг, санал, зөвлөмжийн тоо</li> <li>• Ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдсан маргиналчлагдсан бүлгийн хүүхдийн тоо</li> <li>• Үндэстний цөөнх хүүхдийн СӨБ болон бага боловсролд хамрагдалтын хувь</li> <li>• Гишүүн байгууллагууд өөрсдийн төлөөлсөн бүлгийн хүүхдүүдийн сурч</li> </ul>

	цуглуулж, дүн шинжилгээ хийх, түгээх	эхийн төлөөлөлд танилцуулан зөвлөмж боловсруулах <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн ялгаатай байдал, сурагчдын ялгаатай байдлыг боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тусгах чиглэлээр өөрсдийн байр суурийг боловсруулж хүргэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>○ Жендэрийн мэдрэмжтэй байх</li> <li>○ Багш бэлтгэхээс багшлахуй, үнэлгээнд нэвт шингээх</li> <li>○ ТХЗ 4.7-гийн агуулга буюу иргэний боловсрол</li> <li>○ PISA-н үр дүнд суурилах</li> <li>• Тэгш хамруулсан сайн туршлагыг цуглуулж түгээх замаар тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах</li> <li>• Маргиналчлагдсан бүлгийн суралцагчдын боловсролын эрэлт хэрэгцээ, суралцахуйд тулгарч байгаа саадыг арилгах чиглэлээр нөлөөллийн ажил хийх</li> </ul>	намуудын мөрийн хөтөлбөр, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байна. <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын багц хуулийг дагалдан гарах дүрэм журмууд батлагдан, хэрэгжих нөхцөл бүрдсэн байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбарт эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого, санхүүжилт хангалтгүй байна.</li> </ul>	боловсрох эрхийн хэрэгжилтийн талаар талаар судалгаа, мониторинг хийх чадавх <ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн түвшинд боловсролын чанарыг асжйруулах чиглэлээр нөлөөлөл хийх чадавх</li> </ul>
<b>Сургуулийн/ боловсролын засаглалыг сайжруулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын засаглалын талаарх судалгаа авах, дүн шинжилгээ хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбар дахь сайн засаглал, нийгмийн эгэх хариуцлагын талаарх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхийн оролцоог сургууль, цэцэрлэгийн хувьд шинэ түвшинд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбар дахь сайн засаглал, нийгмийн эгэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын тухай багц хуульд гол оролцогч талуудын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн байгууллагуудтай хамтын бүтээлч оролцоог</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаанд мониторинг хийх</li> <li>Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах чиглэл болон бусад эцэг эхийн оролцоотой холбоотой дүрэм журмуудад үнэлгээ хийх</li> <li>ТХЗ-уудын (ТХЗ 4) хэрэгжилтийг үнэлэх сайн дурын илтгэл бичихэд оролцох (VNR)</li> <li>НҮБ-ын Хүүхдийн эрхийн болон бусад конвенцуудын хэрэгжилтийн байдлаар сүүдэр илтгэл бичих</li> </ul>	<p>мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх</p> <p>мэдээллийн багц бэлтгэх</p> <ul style="list-style-type: none"> <li>Судалгаа, мониторингийн дүнд үндэслэн сургуулийн засаглалыг сайжруулах байр суурийн баримт бичиг боловсруулах</li> <li>Сонгуульд оролцох улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгах саналаа боловсруулах</li> <li>Боловсролын чуулганд жил бүр нийгмийн эгэх хариуцлагын тодорхой сэдэв оруулж зохион байгуулах</li> <li>ТХЗ 4 болон бусад зорилгуудын хэрэгжилтийг хангах чиглэлээр ИНБ-уудын сүлжээний үйл ажиллагаанд идэвхтэй оролцох</li> </ul>	<p>гаргахад нөлөөлөх (мэдээллийн багц, байр суурийн баримт бичгийг ашиглах)</p> <ul style="list-style-type: none"> <li>Оюутан, сурагчдын байгууллагын засаглал дахь оролцоог нэмэгдүүлэх, чанаржуулах, хуульчлах</li> <li>Багш нарын мэргэжлийн холбоо байгуулахад манлайлан оролцох, төлөвшүүлэх үйл явцыг дэмжих</li> <li>СЭЭБХ-г чадавхжуулах</li> <li>Харилцан суралцах, нөлөөллийн 10 арга хэмжээг орон нутагт болон үндэсний хэмжээнд зохион байгуулах</li> </ul>	<p>хариуцлагын талаарх мэдээллийн багц хэвлэгдэн гарсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Багш нарын мэргэжлийн холбоо байгуулагдсан байна.</li> <li>Сайн сургуулийн аргачлалыг 100 сургууль дээр ашигласан байна</li> <li>Боловсролын байгууллагууд оролцогч талуудад хариуцан тайлагнадаг, төсвийн төлөвлөлт, зарцуулалт ил тод, оролцоотой болж хуульчлагдана.</li> </ul>	<p>оролцооны талаар заалт хангалтгүй туссан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Их дээд сургуулиудын Оюутны холбоодтой залуусын байгууллагууд хамтран ажилладаггүй.</li> <li>Сайн засаглал, НЭХ-ын тухай ойлголт хангалтгүй.</li> <li>СЭЭБХ 8 аймгийн 29 суманд 32 байна.</li> <li>НҮБ-ын Хүүхдийн эрхийн болон бусад конвенцуудын хэрэгжилтийн байдлаар сүүдэр илтгэл бичсэн</li> </ul>	<p>хэрэгжүүлдэг гишүүн байгууллагын тоо</p> <ul style="list-style-type: none"> <li>Чадавхажсан СЭЭБХ-ны тоо</li> <li>Орон нутгийн засаг захиргаатай нөлөөллийн уулзалт хийсэн салбар зөвлөл, СЭЭБХ-ны тоо</li> <li>Нийтийн сонсгол зэрэг оролцооны механикуудыг ашигласан гишүүн байгууллага, салбар зөвлөлийн тоо</li> <li>Орон нутгийн боловсролын бүлэг болон бусад бодлогын зөвлөл, ажлын хэсэгт орж ажилласан гишүүн байгууллага, салбарын тоо</li> </ul>
<b>Боловсролын орчин, дотуур</b>	<ul style="list-style-type: none"> <li>Үе тэнгийн дээрэлхэлт, дарамтад өртөж байгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дотуур байрны орчин, нөхцөл, үзүүлэх үйлчилгээний талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн түвшинд хүүхэд хамгааллын үйл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ЕБС-д хүүхэд хамгааллын дүрэм, журмуудын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>2021 оны байдлаар хүүхэд хамгааллын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн сэтгэл зүйч</li> </ul>

<p><b>байран дахь хүүхэд хамгааллыг сайжруулах</b></p>	<p>хүүхдүүдийн нөхцөл байдал, суурь шалтгааныг илрүүлэх судалгаа</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургууль/дотуур байрны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх үнэлгээ хийх</li> <li>• Ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа хүүхдүүдийн нөхцөл байдал, суурь шалтгааныг илрүүлэх судалгаа</li> <li>• Дотуур байрны хүүхэд хамгааллын асуудлаар бодлогын судалгаа</li> <li>• Багш, сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын нөхцөл байдлыг илрүүлэх судалгаа</li> </ul>	<p>эвслийн байр суурийг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтын үлгэрчилсэн агуулга боловсруулах, сургуулиудад түгээх</li> <li>• Боловсролын орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх жишиг журам боловсруулахад хувь нэмэр оруулах</li> <li>• Сэтгэцийн эрүүл мэнд сайн сайхан байдлын судалгаанд үндэслэн сэтгэцийн эрүүл мэндийн сургалтын агуулгыг боловсруулах</li> <li>• Сургуулийн нийгмийн ажил үйлчилгээний талаар мэдээллийн багц боловсруулах</li> </ul>	<p>ажиллагааг сайжруулахад олон нийтийг дайчлах</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын судалгааны дүнг төрд танилцуулж, үр дүнтэй бодлогын шийдэл гаргахад нөлөөлөх</li> <li>• ЕБС-ийн сайн сайхны багт зөвлөн туслах, арга зүйн дэмжлэг үзүүлэх</li> <li>• Ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг компанит аян өрнүүлэх</li> <li>• Сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын ач холбогдлын тухай компанит аян өрнүүлэх</li> </ul>	<p>хэрэгжилт ахисан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• ЕБС-н сайн сайхны баг чадавхжиж, чиг үүргийн дагуу ажиллах чадвар нэмэгдсэн байна</li> <li>• Сургуулийн хамт олны сэтгэцийн эрүүл мэндийн талаар ойлголт нэмэгдсэн байна</li> <li>• СЭЭБХ хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах чадавх бэхэжсэн байна</li> <li>• Сургууль болон дотуур байранд хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоо сайжирсан байна</li> </ul>	<p>бодлогын хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2021 оны ХХБ-ын хэрэгжилтийн үнэлгээгээр 3 хүүхэд тутмын нэг нь сургуулийн орчинд айдастай байдаг</li> <li>• Дотуур байранд 76.2% үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртдөг.</li> <li>• 2021 оны YAR судалгаагаар сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаар залуучууд, тэдний эцэг эхчүүдийн ойлголт хангалтгүй байна.</li> <li>• Хүүхдүүдийн 82.8% нь ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртдөг. 17.1% нь ялгаварлан гадуурхалтад өртдөг<sup>1</sup></li> </ul>	<p>ажиллуулж байгаа сургуулийн тоо</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдлийн үнэлгээ хийсэн сургуулийн тоо</li> <li>• Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар гомдол хүлээн авч шийдвэрлэсэн СЭЭБХ-ны тоо</li> <li>• Сайн сайхны багт дэмжлэг үзүүлэн ажилласан сургуулийн тоо</li> <li>• Кампанит аян өрнүүлсэн сургуулийн тоо</li> <li>• Боловсролыг орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо</li> <li>• Салбар хооронд хүүхэд хамгааллын асуудлаар хамтран баталсан дүрэм, журмын тоо</li> </ul>
--	---	--	--	--	--	---

<sup>1</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2017, ХЭҮК



<p><b>Хөдөлгөөнөө бэхжүүлэх</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Гишүүн байгууллагуудын ялгаатай хэрэгцээ болон эвсэлд тустай байж болох нөөц боломжийг тодорхойлж үйл ажиллагаандаа тусгах</li> <li>• Эвслийн гишүүдийн оролцоо, нөлөөлөл хийх, чадавхыг нэмэгдүүлэх</li> <li>• Эвслийн гишүүд, ажилтнуудын судалгаа хийх, дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх</li> <li>• Эвслийн менежментийн хувьд сайжруулах ямар хэрэгцээ байгааг судалж тогтох</li> <li>• Нэмэлт нөөц санхүүжилтийг (Resource mobilisation) дайчлах боломжийг олж илрүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эвслийн мэдээлэл-харилцааны (Communications) бодлого тодорхойлох</li> <li>• Байгууллагын хөгжлийн стратеги боловсруулах</li> <li>• Байгууллагын мэдлэгийн менежментийн (knowledge management) бодлого тодорхойлох</li> <li>• Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ монитори (monitoring &amp; evaluation) сайжруулах</li> <li>• Байгууллагын жендерийн бодлого тодорхойлох</li> <li>• Эвслийн гишүүд, ажилтнуудын олон улсын байгууллагуудын зохион байгуулагдах хамтран чадавх дээшлүүлэх арга оролцуулж чадварыг нь нэмэгдүүлэх</li> <li>•</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, олон янзат төлөөллийн байгууллагуудыг элсүүлэх</li> <li>• Иргэний нийгмийн байр суурийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах</li> <li>• Маргиналчлагдсан бүлгийн төлөөллийг бодлогын түвшинд оролцуулах, дуу хоолойгоо гаргах боломжийг олгох</li> <li>• Үндэсний түвшинд бодлогын түвшинд оролцоогоо нэмэгдүүлэх, чанаржуулах</li> <li>• Олон улсын түвшинд шинэ түншүүдтэй болох боломжийг хайх</li> <li>• Гишүүн бус дэмжигч бүлгүүдтэй (сайн дурынхан, хуульчдын бүлэг гэх мэт) стратегийн түншлэлээ нэмэгдүүлэх, чанаржуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эвсэл байгууллагын хувьд бэхжих</li> <li>• Гишүүн байгууллагуудын идэвх, оролцоо, хамтын ажиллагаа сайжрах</li> <li>• Орон нутгийн, үндэсний болон бус нутгийн түвшинд түншлэл сайжрах</li> <li>• Орон нутагт сургуулийн эцэг эх, багшийн холбооны тоо нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эвслийн хөгжлийн стратеги бичиг баримт байхгүй</li> <li>• Эвслийн мэдээлэл харилцааны бодлогыг тодорхойлсон бичиг баримт байхгүй</li> <li>• Байгууллагын мэдлэгийн менежментийн тодорхойлсон бичиг баримт байхгүй</li> <li>• Байгууллагын жендерийн бодлогыг тодорхойлсон бичиг баримт байхгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эвслийн хөгжлийн стратеги бичиг баримттай болох</li> <li>• Гишүүдэд зориулсан жилд 3 сургалт хийх</li> <li>• Гишүүдэд бусад байгууллагуудын нөөц боломжийг таниулах 2 үйл ажиллагаа (skills market)</li> <li>• Дор хаяж нэг нэмэлт санхүүжүүлэгчтэй болох</li> <li>• Дор хаяж нэг гадаад шинэ түнш байгууллагатай болох</li> <li>• Эвслийн гишүүд, ажилтнуудын олон улсын байгууллагуудын зохион байгуулагдах дор хаяж 4 сургалтад хамруулах</li> </ul>
-------------------------------------	---	---	--	---	--	--